

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ 1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, түүнд хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоож,хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах,ашиглахад төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.	2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулна: 1/ худалдаа, үйлчилгээний тооцоо; 6.Баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглоно. 7.Ахуйн зориулалттай хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулахгүй бөгөөд түүнийг худалдаа, үйлчилгээний тооцоонд хэрэглэхийг хориглоно. 2. Хэмжилзүйн төв байгууллага нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, суурилуулалт, засвар, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 11 дүгээр зүйл. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт 2. Савласан, боосон,түүнчлэн ширхэгээр худалдах бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утга нь түүний холбогдох стандарт болон сав, боодол дээр буюу дагалдах баримт бичигт тэмдэглэсэн тоон хэмжээний хэвийн утгатай, тодорхой нэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хязгаартай тус тус тохирч байна.